

**МОНГОЛ УЛСЫН
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/374

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 11.5 дахь заалт, АШУУИС-ийн дүрмийн 3.2 дахь заалт, АШУУИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/318 тоот тушаал, АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн Тэргүүлэгч Гишүүдийн 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. АШУУИС-ийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг нэгдүгээр хавсралтаар, Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журмыг хоёрдугаар хавсралтаар, Эрдмийн цол олгох журам, “Профессор”, “Дэд профессор”, “Клиникийн профессор” цолд нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Журам батлагдсантай холбогдуулан АШУУИС-ийн Захирлын 2015 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/53 тоот тушаалыг хүчингүйд тооцож, тушаалыг баталсан өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хөгжлийн бодлого эрхэлсэн дэд захирал /Б.Амарсайхан/, Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга /Д.Бат-Ундрах/, Эрдмийн сургуулийн захирал /Б.Дамдиндорж/ нарт тус тус даалгасугай.

ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЦОЛМОН



МОНГОЛ УЛСЫН АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН “ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсын Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Эрдмийн Зөвлөл нь Монгол улсын дээд боловсролын тухай хууль болон АШУУИС-ийн дүрэмд зааснаар Монгол улсын анагаахын шинжлэх ухааны салбарын сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажлын чиглэлийг тогтоож, дээрх асуудлаар хэлэлцэж санал, дүгнэлт гаргах хамтын удирдлагын эрдмийн байгууллага юм.
- 1.2. Эрдмийн Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Эрдмийн зөвлөлийн хуралдаан байна.


Хоёр. Эрдмийн Зөвлөлийн зохион байгуулалт, бүрэлдэхүүн

- 2.1. АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөлийг салбарын тэргүүлэх эрдэмтэн, профессор цолтой 21-ээс доошгүй гишүүдээс бүрдүүлж, их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор тухайн салбарын 4 хүртэл эрдэмтнээр өргөтгөн хуралдаж болно.
- 2.2. АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөл нь Эрдмийн Зөвлөлийн дарга, орлогч дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга, тэргүүлэгч гишүүн, үндсэн гишүүнээс бүрдсэн бүтэц, бүрэлдэхүүнтэй байна. Эрдмийн Зөвлөлийн тэргүүлэгч гишүүд ёслолын өмсгөлтэй байна.
- 2.3. АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн дарга нь АШУУИС-ийн захирал байна. Эрдмийн зөвлөлийн орлогч дарга нь Эрдэм Шинжилгээ хариуцсан дэд захирал байх бөгөөд Эрдмийн Зөвлөлийн даргын эзгүйд, эсвэл түүнийг үүргээ гүйцэтгэх боломжгүй үед орлон ажиллана. Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь хурлын бэлтгэлийг хангах, Эрдмийн Зөвлөлийн бичиг хэргийг бүртгэн хөтлөх, Эрдмийн Зөвлөлийн тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, бүрэлдэхүүн сургуулиудын эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн гаргах ажлыг хариуцна.
- 2.4. АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөлөөр сонгогдох гишүүдийн оронтоо(квот)-г Эрдмийн Зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаас тогтооно. Тогтоосон орон тоонд үндэслэн Бүрэлдэхүүн сургууль тус бүрийн доктор ба түүнээс дээш зэрэг цолтой багш, судлаачдын гуравны хоёроос дээш ирцтэй хуралд нэр дэвшигчдийг танилцуулж, ил санал хураалтаар шийднэ. Хурлаас гарсан шийдвэрийг Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн, АШУУИС-ийн захиралд хүргүүлж баталгаажуулна. АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн гишүүнээр сонгогдох нэр дэвшигч нь доктор, профессор ба түүнээс дээш эрдмийн зэрэг, цолтой багш, судлаач, эрдэмтэн байна. АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн гишүүний сонгуулийг 2 жил тутамд явуулна.
- 2.5. АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн бүрэлдэхүүнд сонгогдсон гишүүдээс эрдэмтэн нарийн бичгийн дарга, тэргүүлэгч гишүүдийг Эрдмийн Зөвлөлийн дарга санал болгож батална.
- 2.6. Эрдмийн Зөвлөлийн гишүүн нь Эрдмийн Зөвлөлийн хурлын гуравны нэгийг хүндэтгэх шалтгаангүйгээр таслах, эсвэл нэг хичээлийн жилээс дээш хугацаагүйгээр эзгүй байх, эсвэл сул орон тоо гарсан тохиолдолд тухайн бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн

- зөвлөлөөс ирүүлсэн саналын жагсаалтын дараагийн нэр дэвшигчийг нөхөн сонгож, захирлын тушаалаар батална.
- 2.7. АШУҮИС нь Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлүүд болон Анагаах ухааны боловсрол судлалын Эрдмийн зөвлөлтэй байна.
- 2.8. АШУҮИС-ийн Эрдмийн Зөвлөл нь АШУҮИС-ийн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.


Гурав. Эрдмийн Зөвлөлийн үйл ажиллагаа

- 3.1. Эрдмийн Зөвлөлийн шийдвэрийг Эрдмийн Зөвлөлийн хуралдаанаар гаргана.
- 3.2. Эрдмийн Зөвлөлийн хуралдаанаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж, хурлын тогтоол, шийдвэр гаргана. Үүнд:
- 3.2.1. АШУҮИС-ийн дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх
- 3.2.2. Дээд боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан, технологийн талаарх төрийн бодлогод нийцүүлэн АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, сургуулиас баримтлах бодлогын баримт бичиг, хөтөлбөрийг хэлэлцэх
- 3.2.3. АШУҮИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой журмуудыг хэлэлцэж, өөрчлөлт оруулах саналаа захиргаанд хүргэж шийдвэрлүүлэх
- 3.2.4. АШУҮИС-ийн төгсөлтийн өмнөх, төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, стандартыг боловсруулах, батлах, үнэлэх үүрэг бүхий хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах
- 3.2.5. БСШУСЯ-ны ШУТС-ийн санхүүжилттэй судалгааны төслүүд, АШУҮИС-ийн ШУТДС-ийн санхүүжилттэй Ахисан төвшний судалгааны төсөл, Инноваци, технологи дамжуулах төсөл, Салбар дундын судалгааны төсөл, Өртөг хуваалцах хамтарсан судалгааны төсөл, Шилдэг судлаачдыг дэмжих урамшуулал, Судалгааны хүрээлэн, төв, лабораторийн үйл ажиллагааны дэмжлэг болон олон улсын санхүүжилттэй хамтарсан төслүүдийн эцсийн үр дүн, тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах
- 3.2.6. Эрдмийн зэрэг, цол олгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх
- 3.2.7. Эрдмийн сургуулийн шийдвэрийг үндэслэн PhD докторын зэрэг горилсон бүтээлийн урьдчилсан хамгаалалтыг хэлэлцэн санал, дүгнэлт гаргах, албан ёсны шүүмжлэгчийг томилох
- 3.2.8. Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээлийг хэлэлцэн санал дүгнэлт гаргах
- 3.3. Эрдмийн Зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаас дараах асуудлаар тогтоол, шийдвэр гаргана. Үүнд:
- 3.3.1. АШУҮИС-ийн “хүндэт доктор”, “хүндэт профессор”, “зочин профессор”, “профессор”, “дэд профессор”, “клиникийн профессор”-ын шалгуур үзүүлэлтийг биелүүлсэн, холбогдох журмын дагуу цол олгуулахаар бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөс нэр дэвшүүлсэн эрдэмтдийн асуудлыг Эрдмийн зөвлөлийн даргын шийдвэрээр томилсон шинжээчдийн комиссоос гаргасан дүгнэлтийг хэлэлцэн баталгаажуулж, АШУҮИС-ийн Эрдмийн Зөвлөлийн хуралдаанаар шийдүүлэхээр хүргүүлэх
- 3.3.2. Эрдмийн зөвлөлийн даргын шийдвэрээр томилсон шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн АШУҮИС-ийн Эрдмийн шилдэг бүтээлд нэр дэвшсэн бүтээлийг хэлэлцэн шийдвэрлэх



Дөрөв. Эрдмийн Зөвлөл, түүний гишүүдийн эрх, үүрэг

- 4.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд дараах үндсэн зарчмыг баримтлах
 - 4.1.1. Хууль дээдлэх
 - 4.1.2. Эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх
 - 4.1.3. Бие даасан хараат бус байх
 - 4.1.4. Хариуцлагатай, өндөр ёс суртахуунтай, ёс зүйтэй байх
 - 4.1.5. Эрдэмтний нэр төрийг дээдлэх
 - 4.1.6. Эрдмийн зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хууль дүрмийн дагуу, тасралтгүй, үр ашигтай зохион байгуулах бүхий л талын боломж нөхцөлөөр хангах
- 4.2. Эрдмийн зөвлөлийн эрх
 - 4.2.1. Сургуулийн хөгжлийн төлөв, эрдэм шинжилгээ, технологийн шинэчлэлтэй холбоотой бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн салбарын боловсон хүчин бэлтгэх хөтөлбөр, стандарт, дүрэм журмыг хэлэлцэн, санал дүгнэлтээ гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх
 - 4.2.2. Улсын төсвөөр хийгдэх эрдэм шинжилгээний төсөлт ажлыг захиалахаар санал дэвшүүлэх, төслийн эцсийн үр дүнг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт гаргах
 - 4.2.3. Боловсрол, Эрүүл мэнд, Шинжлэх ухааны тулгамдсан асуудлаар санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх, асуулга тавих
 - 4.2.4. Төр, төрийн бус болон Олон улсын эрдэм шинжилгээний байгууллагын нэр хүндтэй шагналд нэр дэвшсэн боловсрол, эрдэм шинжилгээ, технологийн шилдэг бүтээлийг хэлэлцэж, санал дүгнэлтээ хүргүүлэх
 - 4.2.5. АШУУИС-ийн захирлын тушаалаар батлагдсан Эрдмийн зөвлөлийн гишүүд шинээр сонгогдсоноор өмнөх Эрдмийн зөвлөлийн гишүүний эрх тасалбар болно.
- 4.3. Эрдмийн Зөвлөлийн үүрэг
 - 4.3.1. АШУУИС-ийн сургалт, судалгаа, шинжлэх ухаан технологи, инноваци, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар баримтлах бодлогыг боловсруулах
 - 4.3.2. Сургуулийн шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлоготой нийцсэн дотоод болон гадаад хамтын ажиллагааг дэмжих
- 4.4. Эрдмийн Зөвлөлийн гишүүдийн эрх
 - 4.4.1. Эрдмийн Зөвлөлд асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх, сонгох, сонгогдох
 - 4.4.2. Эрдмийн Зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох, ажлаа үнэлүүлэх, урамшуулал авах
 - 4.4.3. Эрдмийн Зөвлөлийн үйл ажиллагааны талаар санал тавих, шүүмжлэх, хэлэлцэж буй асуудлаар саналын зөрөөтэй байдлаа хурлын тэмдэглэлд тэмдэглүүлэх
 - 4.4.4. Эрдмийн Зөвлөлийн гишүүнээс татгалзах
- 4.5. Эрдмийн Зөвлөлийн гишүүд нь дараах үүргийг хүлээнэ.
 - 4.5.1. Эрдмийн Зөвлөлийн хуралдаан, Эрдмийн Зөвлөлөөс зохион байгуулсан бусад арга хэмжээнд идэвхтэй оролцох, шийдвэрийг биелүүлэх
 - 4.5.2. Шинжлэх ухааныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, залгамж халааг бэлтгэх
 - 4.5.3. Эрдмийн Зөвлөлийн нэр хүндийг хамгаалах, хамтын шийдвэрийг мөрдөх
 - 4.5.4. Эрдмийн Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлэх
 - 4.5.5. Эрдмийн Зөвлөлийн гишүүн хуралдаанд оролцох боломжгүй бол энэ




тухайгаа хуралдаан эхлэхээс өмнө нарийн бичгийн даргад мэдэгдэх, хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр таслахгүй байх

- 4.6. Эрдмийн Зөвлөлийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.6.1. Сургалт, судалгаа, шинжлэх ухаан технологи, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар баримтлах их сургуулийн хөгжлийн бодлого, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, эрдмийн зөвлөлд тайлагнах
 - 4.6.2. Эрдмийн зөвлөлийн хуралдааныг удирдах
 - 4.6.3. Эрдмийн Зөвлөлийн хуралдааны шийдвэрийг даган мөрдөж биелүүлэх
- 4.7. Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.7.1. Эрдмийн зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах
 - 4.7.2. Эрдмийн Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтлөлтөд хяналт тавих
 - 4.7.3. Эрдмийн Зөвлөлийн тогтоол шийдвэр, бичиг хэргийг бүртгэн хөтлөх, архивт хадгалуулах, түүний биелэлтэд хяналт тавих
 - 4.7.4. Эрдмийн зэрэг, цол олгох болон бусад хүндэтгэлийн ёслолын ажлыг зохион байгуулах
- 4.8. Эрдмийн зөвлөлийн гишүүний ёс зүйн хэм, хэмжээ
 - 4.8.1. Эрдмийн зөвлөлийн гишүүд АШУУИС-ийн Эрдмийн зөвлөлийн үндсэн зарчимд тулгуурлан эрдмийн зөвлөлийн хуралдааны дэгийг чанд баримталж, ёс зүйтэй ажиллах
 - 4.8.2. Эрдмийн зөвлөлийн үндсэн зарчмыг баримтлахгүй байх, түүнд харшлах санал дүгнэлт хэлэх, эрдмийн зэрэг, цол горилогчид болон хувь судлаач, судалгааны багт хандаж хувийн дүгнэлт хийх, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, хуралдааны дэгийг зөрчих, хэлэлцэж буй асуудлаас өөр асуудлаар санал дүгнэлт өгөх зэрэг ёс зүйн алдаа гаргахгүй байх
 - 4.8.3. Ёс зүйн алдаа гаргасан гишүүнийг Эрдмийн зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлын шийдвэрт үндэслэн Эрдмийн зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх

Тав. Эрдмийн Зөвлөлийн хуралдаан, түүний дэг, гаргах шийдвэр


- 5.1. Эрдмийн Зөвлөлийн хуралдаан ба Эрдмийн Зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлыг Эрдмийн Зөвлөлийн дарга, түүний эзгүйд Эрдмийн Зөвлөлийн орлогч дарга зарлан хуралдуулж даргална. Дарга, орлогч дарга хоёул эзгүйд Эрдмийн Зөвлөл хуралдахгүй.
- 5.2. Эрдмийн Зөвлөлийн ээлжит бус хурлыг Эрдмийн Зөвлөлийн дарга, эсвэл гишүүдийн гуравны нэгийн шаардлагаар эрдэмтэн нарийн бичгийн дарга ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө зарлан хуралдуулж болно.
- 5.3. Эрдмийн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой бичиг баримтыг хуралдаанаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд хүргүүлсэн байна.
- 5.4. Эрдмийн Зөвлөлийн хуралдаанд гишүүдийн 75%-иас доошгүй хувийн ирцтэй тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.
- 5.5. Хурлын дарга хуралдааны эхэнд хэлэлцэх асуудал, дэгийг танилцуулж батлуулсны дараа түүний дагуу хуралдааныг удирдана.
- 5.6. Хуралдаанд асуулт асуух, үг хэлэх, тайлбар тавих зөвшөөрлийг хурлын дарга олгоно.
- 5.7. Энэ дэгийг Эрдмийн Зөвлөлийн тэргүүлэгчдийн хуралдаанд мөн баримтална. Эрдмийн Зөвлөлийн тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар 3-аас дээш гишүүн уг асуудлыг Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцэх санал гаргавал ёсоор болгоно.




- 5.8. Эрдмийн зөвлөлийн хуралдааныг нээлттэй хийнэ. Хуралдаанд АШУУИС-ийн багш, ажилтан, албан хаагчид сууж болно. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хуралдааныг хаалттай хийж болно.
- 5.9. АШУУИС-ийн “Хүндэт доктор”, “Хүндэт профессор”, “Зочин профессор” цолыг “АШУУИС-ийн хүндэт доктор, хүндэт профессор, зочин профессор цол олгох журам”-ын дагуу шийдвэрлэнэ.
- 5.10. АШУУИС-ийн “Профессор”, “Дэд профессор”, “Клиникийн профессор” цолыг “АШУУИС-ийн Эрдмийн цол олгох журам”-ын дагуу шийдвэрлэнэ.
- 5.11. Докторын (PhD) урьдчилсан хамгаалалт, шинжлэх ухааны докторын ажилд санал дүгнэлт гаргахтай холбоотой асуудлыг “АШУУИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасны дагуу шийдвэрлэх бөгөөд “Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.1-д заасны дагуу тухайн салбарын 4 хүртэл тэргүүлэх эрдэмтдээр өргөтгөн хуралдуулж болно.
- 5.12. Хуралдааны төгсгөлд хэлэлцсэн асуудлаар Эрдмийн Зөвлөлийн хурлын тогтоолын төслийг танилцуулж батлуулна. Хурлын явцад тэмдэглэл хөтлөх ба хурлын тэмдэглэл, тогтоолыг Эрдмийн Зөвлөлийн дарга, Эрдэмтэн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

Зургаа. Эрдмийн Зөвлөлийн санхүүжилт

- 6.1. Эрдмийн Зөвлөлийн үйл ажиллагаа нь дараах эх үүсвэрээс санхүүжнэ.
- 6.1.1. АШУУИС-ийн төсөв
- 6.1.2. Бусад эх үүсвэр
- 6.2. Эрдмийн Зөвлөлийн төсвийг дараах арга хэмжээнд зарцуулна. Үүнд:
- 6.2.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны чиг үүргийн дагуу хуралдсан эрдмийн зөвлөлийн гишүүдийн цагийн урамшуулал
- 6.2.2. Эрдмийн Зөвлөлөөс тодорхой асуудлаар томилогдсон шинжээчдийн баг, ажлын хэсгийн гишүүдийн цагийн урамшуулал
- 6.2.3. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн ирцийн бүртгэл, асуудлыг шийдвэрлэхэд оруулсан хувь нэмэр зэргийг үндэслэн олгох урамшуулал
- 6.2.4. Урамшууллын хэмжээг АШУУИС-ийн захирлын тушаалаар батлана. Шаардагдах хөрөнгийг төсөвт суулгасан байна.





АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбарын Эрдмийн Зөвлөл нь Монгол улсын дээд боловсролын тухай хууль, АШУУИС-ийн дүрэм, АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн журамд зааснаар бүрэлдэхүүн сургууль, салбарын хамтын удирдлагын эрдмийн байгууллага мөн.
- 1.2. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөл нь бүрэлдэхүүн сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэлэлцэн чиглэл тогтоох, ач холбогдол, үр дүнд үнэлэлт, санал дүгнэлт өгөх, шийдвэр гаргах үүрэгтэй байна.


Хоёр. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн зохион байгуулалт, бүрэлдэхүүн

- 2.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөл нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга бүхий салбарын тэргүүлэх эрдэмтдээс бүрдсэн байна. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн гишүүдийн бүтэц, бүрэлдэхүүнийг АШУУИС-ийн “Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг жишиг болгон баримталж, бүрдүүлэн, АШУУИС-ийн захирлын тушаалаар байгуулна.
- 2.2. АШУУИС-ийн Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн дарга нь бүрэлдэхүүн сургуулийн захирал, профессор цолтой эрдэмтэн байна.
- 2.3. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хуралдааныг эрдмийн зөвлөлийн дарга, түүний эзгүйд, орлогч дарга зарлан хуралдуулна. Дарга, орлогч дарга хоёул эзгүйд бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөл хуралдахгүй.
- 2.4. Нарийн бичгийн дарга нь хурлын бэлтгэлийг хангах, Эрдмийн Зөвлөлийн тогтоол шийдвэрийн биелэлтийг хянах, сургуулийн эрдэм шинжилгээний ажлын үр дүнг нэгтгэх, Эрдмийн Зөвлөлийн бичиг хэргийг бүртгэн хөтлөх ажлыг хариуцна.
- 2.5. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн гишүүнийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн доктороос дээш зэрэг, цолтой багш, судлаачдын гуравны хоёроос доошгүй ирцтэй хурлаас ил санал хураалтаар сонгож, АШУУИС-ийн захирлын тушаалаар батлуулна.
- 2.6. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн нэмэлт гишүүнийг Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга санал болгож, АШУУИС-ийн захирлын тушаалаар батлуулна.
- 2.7. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн гишүүний сонгуулийг 2 жил тутамд явуулна.
- 2.8. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүн нэг хичээлийн жилээс дээш хугацаагаар эзгүй байх, өөрийн хүсэлтээр буюу албан ажлын шаардлагаар зөвлөлийн гишүүнээс татгалзсан, хичээлийн жилийн хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр хурлын гуравны нэгийг тасалсан, сул орон тоо гарах зэрэг тохиолдолд тухайн бүрэлдэхүүн сургуулийн сонгуулийн жагсаалтын дараагийн нэр

- дэвшигчийг гишүүнээр сонгож, АШУҮИС-ийн захирлын тушаалаар батлуулна.
- 2.9. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны чиг хүрээнд болон Төгсөлтийн сургалттай холбоотой асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд шаардлагатай бол тухайн шинжлэх ухааны салбарын нэр хүндтэй 4 хүртэл тэргүүлэх эрдэмтдээр өргөтгөн хуралдуулж болно.
- 2.10. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөл нь бүрэлдэхүүн сургуулийн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Гурав. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн үйл ажиллагаа


- 3.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн шийдвэрийг Эрдмийн Зөвлөлийн хурлаас гаргана.
- 3.2. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хуралдаанаас дараах асуудлаар шийдвэр гаргана. Үүнд:
- 3.2.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн журам, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн, санал дүгнэлтээ АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлд хүргүүлэх
- 3.2.2. Бүрэлдэхүүн Сургуулийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, сургуулиас баримтлах бодлогын баримт бичиг, хөтөлбөрийг хэлэлцэн санал дүгнэлт гаргах
- 3.2.3. Бүрэлдэхүүн Сургуулийн эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэлийг батлан Эрдмийн зөвлөл, Эрдмийн сургууль, ШУТГ-г хүргүүлэх
- 3.2.4. Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, стандартыг хэлэлцэх, санал, дүгнэлт гарган Хөтөлбөрийн хороонд хүргүүлэх
- 3.2.5. Бүрэлдэхүүн сургуулийн үйл ажиллагааны тайланг авч хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын зорилго чиглэлийг тодорхойлон, санал гаргах, захиргаанд хүргүүлэх
- 3.2.6. Гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох, гэрээ хэлэлцээр байгуулах асуудлыг хэлэлцэн санал дүгнэлт гаргах, захиргаанд хүргүүлэх
- 3.2.7. АШУҮИС-ийн “Хүндэт доктор”, “Хүндэт профессор”, “Зочин профессор” цол олгох асуудлыг “АШУҮИС-ийн хүндэт доктор, хүндэт профессор, зочин профессор олгох журам”-ын дагуу хэлэлцэн шийдвэрлэж Эрдмийн зөвлөлд хүргүүлнэ.
- 3.2.8. АШУҮИС-ийн “Профессор”, “Дэд профессор”, “Клиникийн профессор” цол олгох асуудлыг “АШУҮИС-ийн Эрдмийн цол олгох журам”-ын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, АШУҮИС-ийн Эрдмийн Зөвлөлд хүргүүлэх
- 3.2.9. Эрдмийн шилдэг бүтээлийн шагнал олгуулахаар мэргэжлийн тэнхимээс санал болгосон бүтээлийг хэлэлцэн шийдвэр гаргах, саналыг АШУҮИС-ийн Эрдмийн Зөвлөлд хүргүүлэх
- 3.2.10. АШУҮИС-ийн ШУТДС болон Төр, Хувийн хэвшлийн байгууллага, ТББ-тай хамтран хийгдэх эрдэм шинжилгээний төсөлт ажлыг захиалахаар санал дэвшүүлэх, төслийн явцын хэлэлцүүлгийг хийж үнэлэлт өгөх, санал, зөвлөмжөө холбогдох газруудад хүргүүлэх
- 3.2.11. АШУҮИС-ийн ШУТДС-ийн санхүүжилттэй Докторын дараах судалгааны тэтгэлэг, Зочин судлаачийн судалгааны төсөл, Судлаачдыг чадавхжуулах богино хугацааны сургалтын тэтгэлгийн санхүүжилтийн квотыг тогтоох, үр дүн ба санхүүгийн эцсийн тайланг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт гарган АШУҮИС-ийн захиргаанд хүргүүлэх



3.2.12. Докторын болон магистрын зэрэг горилогчийн ажилд санал дүгнэлт гаргахтай холбоотой асуудлыг АШУҮИС-ийн “Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасны дагуу шийдвэрлэн, Эрдмийн сургуульд хүргүүлэх

Дөрөв. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөл, түүний гишүүдийн эрх, үүрэг

- 4.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөл нь дараах эрхийг эдэлнэ.
 - 4.1.1. Бүрэлдэхүүн Сургуулийн хөгжлийн төлөв, эрдэм шинжилгээ, технологийн шинэчлэлтэй холбоотой бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн бодлого, эрүүл мэндийн салбарын боловсон хүчин бэлтгэхтэй холбоотой хөтөлбөр, стандарт, дүрэм журмыг хэлэлцэх, санал дүгнэлт гаргах
 - 4.1.2. Эрүүл мэнд, Боловсрол, Шинжлэх ухааны тулгамдсан асуудлаар санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх, асуулга тавих
 - 4.1.3. Боловсрол, эрдэм шинжилгээ, технологийн шилдэг бүтээлийг хэлэлцэж төр, төрийн бус болон олон улсын байгууллагын шагналд нэр дэвшүүлэх саналаа АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлд хүргүүлэх
 - 4.1.4. АШУҮИС-ийн Эрдмийн цол олгуулахаар нэр дэвшүүлсэн эрдэмтдийн мэргэжлийн тэнхимээс гаргасан саналыг “АШУҮИС-ийн Эрдмийн цол олгох журам”-ын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, АШУҮИС-ийн Эрдмийн Зөвлөлд хүргүүлэх
- 4.2. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөл нь дараах үүргийг хүлээнэ.
 - 4.2.1. Бүрэлдэхүүн сургуулийн сургалт, судалгаа, шинжлэх ухаан технологи, инноваци, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар баримтлах бодлогыг боловсруулах
 - 4.2.2. Сургуулийн шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлоготой нийцсэн дотоод болон гадаад хамтын ажиллагааг дэмжих
- 4.3. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн гишүүд нь дараах эрхийг эдэлнэ.
 - 4.3.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлд асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх, сонгох, сонгогдох
 - 4.3.2. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох, ажлаа үнэлүүлэх, урамшуулал авах
 - 4.3.3. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн үйл ажиллагааны талаар санал тавих, шүүмжлэх, саналын зөрөөтэй байдлаа хурлын тэмдэглэлд тэмдэглүүлэх
 - 4.3.4. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн гишүүнээс татгалзах
 - 4.3.5. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга нар АШУҮИС-ийн багшийн цагийн ачаалал тооцуулах журмын дагуу сургалтын ачааллаас хөнгөлөлт эдлэх
- 4.4. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн гишүүд нь дараах үүргийг хүлээнэ.
 - 4.4.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хурал, Эрдмийн Зөвлөлөөс зохион байгуулсан бусад арга хэмжээнд идэвхтэй оролцох
 - 4.4.2. Шинжлэх ухааныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, залгамж халааг бэлтгэх
 - 4.4.3. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн нэр хүндийг хамгаалах, хамтын шийдвэрийг дагаж мөрдөх
 - 4.4.4. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлэх
- 4.5. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүний ёс зүйн хэм хэмжээг дагаж



мөрдөх


- 4.5.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүд АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн үндсэн зарчимд тулгуурлан, хуралдааны дэгийг чанд баримталж, ёс зүйтэй ажиллах
- 4.5.2. АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн үндсэн зарчмыг баримтлахгүй байх, түүнд харшлах санал дүгнэлт хэлэх, эрдмийн зэрэг, цол горилогчид болон хувь судлаач, судалгааны багт хандаж хувийн дүгнэлт хийх, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, хуралдааны дэгийг зөрчих, хэлэлцэж буй асуудлаас өөр асуудлаар санал дүгнэлт өгөх зэрэг ёс зүйн алдаа гаргахгүй байх
- 4.5.3. Ёс зүйн алдаа гаргасан гишүүнийг Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Эрдмийн зөвлөлийн гишүүнээс чөлөөлнө.
- 4.5.4. Чөлөөлөгдсөн гишүүний оронд тухайн бүрэлдэхүүн сургуулийн сонгуулийн жагсаалтын дараагийн нэр дэвшигчийг гишүүнээр сонгож, АШУҮИС-ийн захирлын тушаалаар батална.

Тав. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хурал, түүний дэг, шийдвэр гаргах


- 5.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хурлыг Эрдмийн Зөвлөлийн дарга, түүний эзгүйд Эрдмийн Зөвлөлийн орлогч дарга зарлан хуралдуулж даргална.
- 5.2. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой бичиг баримтыг хуралдаанаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд хүргүүлсэн байна.
- 5.3. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хуралдаанд гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.
- 5.4. Хурлын дарга хуралдааны эхэнд хэлэлцэх асуудал, дэгийг танилцуулж баталсны дараа түүний дагуу хуралдааныг удирдана.
- 5.5. Хуралд асуулт асуух, үг хэлэх, тайлбар тавих зөвшөөрлийг хурлын дарга олгоно.
- 5.6. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ.
- 5.7. Төгсөлтийн сургалттай холбоотой асуудлыг “АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасны дагуу шийдвэрлэнэ
- 5.8. Хуралдааны төгсгөлд хэлэлцсэн асуудлаар Эрдмийн Зөвлөлийн хурлын тогтоолын төслийг танилцуулж батлуулна. Хурлын явцад тэмдэглэл хөтлөх ба хурлын тэмдэглэл, шийдвэрийг Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн дарга, Эрдмийн Зөвлөлийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

Зургаа. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн санхүүжилт


- 6.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн үйл ажиллагаа нь дараах эх үүсвэрээс санхүүжнэ
 - 6.1.1. Бүрэлдэхүүн Сургуулийн төсөв
 - 6.1.2. Бусад эх үүсвэр
- 6.2. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн төсвийг дараах арга хэмжээнд зарцуулна.
 - 6.2.1. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны чиг үүргийн дагуу хуралдсан эрдмийн зөвлөлийн гишүүдийн цагийн урамшуулал
 - 6.2.2. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлөөс тодорхой асуудлаар томилогдсон шинжээчдийн баг, ажлын хэсгийн гишүүдийн цагийн урамшуулал
 - 6.2.3. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн ирцийн бүртгэл, асуудлыг шийдвэрлэхэд оруулсан хувь нэмэр зэргийг үндэслэн олгох урамшуулал



6.2.4. Урамшууллын хэмжээг АШУУИС-ийн захирлын тушаалаар тогтооно. Шаардагдах хөрөнгийг Бүрэлдэхүүн сургуулийн төсөвт суулгасан байна.



---o0o---



АШУУИС-ИЙН ЭРДМИЙН ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журам нь АШУУИС-ийн “профессор”, “дэд профессор”, “клиникийн профессор” цол олгохтой холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэ журам нь Анагаах ухааны боловсролын хөгжилд АШУУИС-ийн эрдэмтэн, багш, судлаачид, эмч нарын оруулсан хувь нэмрийг үнэлэх, тэднийг алдаршуулах зорилготой.
- 1.3. АШУУИС-ийн эрдмийн цолонд тавигдах шаардлагыг уг журамд тусгаж, Эрдмийн Зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тогтоолоор баталж, АШУУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 1.4. АШУУИС-ийн Эрдмийн зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар тухайн хичээлийн жилд АШУУИС-ийн Эрдмийн цол олгох орон тоо(квот)-г хэлэлцэн батална.
- 1.5. Эрдмийн Зөвлөлөөр АШУУИС-ийн эрдмийн цолд нэр дэвшүүлэх, хэлэлцэх асуудлыг тухайн хичээлийн жилд 1 удаа зохион байгуулна. Нэр дэвшигчийн материалыг хүлээн авах, үнэлгээ хийх хугацааг Эрдмийн Зөвлөлийн Тэргүүлэгчдээс тогтоож зарлана. Хугацаанаас хожимдсон материалыг хүлээн авахгүй.

Хоёр. Нэр дэвшигчдийн бүрдүүлэх материал


- 2.1. Профессор цолд нэр дэвшигчид дараах материалыг бүрдүүлнэ.
 - 2.1.1. Ажил байдлын тодорхойлолт
 - 2.1.2. Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар баталгаажуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажилтай холбоотой бүтээлийн жагсаалт
 - 2.1.3. Доктор, дэд профессорын үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар
 - 2.1.4. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжсэн хурлын тэмдэглэл
 - 2.1.5. Удирдаж хамгаалуулсан 2-оос доошгүй докторын нэг сэдэвт бүтээлийн хураангуй
2. 2. Дэд профессор цолонд нэр дэвшигчид дараах материалыг бүрдүүлнэ.
 - 2.2.1. Ажил байдлын тодорхойлолт
 - 2.2.2. Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар баталгаажуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажилтай холбоотой бүтээлийн жагсаалт
 - 2.2.3. Докторын үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар
 - 2.2.4. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжсэн хурлын тэмдэглэл
 - 2.2.5. Удирдаж хамгаалуулсан доктор, магистрын нэг сэдэвт бүтээлийн хураангуй
2. 3. Клиникийн профессор цолонд нэр дэвшигчид дараах материалыг бүрдүүлнэ.
 - 2.3.1. Ажил байдлын тодорхойлолт
 - 2.3.2. Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар баталгаажуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажилтай холбоотой бүтээлийн жагсаалт
 - 2.3.3. Мэргэжлийн зөвлөх, тэргүүлэх зэргийн үнэмлэх, PhD докторын зэргийн үнэмлэхийн баталгаажуулсан хуулбарын аль нэг
 - 2.3.4. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжсэн

хурлын тэмдэглэл


- 2.3.5. Сургуулийн хөгжилд оруулсан хувь нэмрийг баталгаажуулсан баримт, буюу оюутны хичээл, дадлага, резидент, төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалт удирдаж байсныг баталгаажуулах баримт

Гурав. АШУУИС-ийн эрдмийн цол олгуулахаар нэр дэвшүүлэх, шалгаруулах

- 3.1. АШУУИС-ийн “профессор”, “дэд профессор” “клиникийн профессор” цолд багш нарын ажлыг үнэлж нэр дэвшүүлэхдээ дараах 3 нөхцөлөөр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн түгээмэл шалгуур үзүүлэлт, зарчмыг баримтлан шалгаруулна.
- 3.1.1. Олон улсын нэр хүндтэй (“Web of Science” мэдээллийн сан) эрдэм шинжилгээний 15-аас дээш импакт фактор бүхий сэтгүүлд нэгдүгээр буюу хариуцлагатай зохиогчоор АШУУИС-ийн нэр дээр 1 өгүүлэл хэвлүүлж, 2-оос цөөнгүй докторант удирдаж хамгаалуулсан эрдэмтэнд “профессор” цолны, 10-аас дээш импакт фактор бүхий сэтгүүлд нэгдүгээр буюу хариуцлагатай зохиогчоор АШУУИС-ийн нэр дээр 1 өгүүлэл хэвлүүлж, 1-ээс цөөнгүй докторант удирдаж хамгаалуулсан эрдэмтэнд “дэд профессор” цолны болзлыг биелүүлсэнд тооцож, АШУУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар батламжлан олгоно.
- 3.1.2. Дэлхийн их сургуулийн эрэмбийг тогтоодог “Quacquarelli Symonds” (QS) байгууллагатай хамтран, АШУУИС-ийг эрэмбэлүүлэх зорилттой уялдуулан тухайн гориллогчийн “Scopus” мэдээллийн санд бүртгэгдсэн бүтээлийн H-индекс 7-аас багагүй, бүтээлийн ишлэгдсэн тоо 300-аас цөөнгүй, 2-оос доошгүй докторант удирдаж хамгаалуулсан бол “профессор” цолыг, “Scopus” мэдээллийн санд бүртгэгдсэн бүтээлийн H-индекс 5-аас багагүй, бүтээлийн ишлэгдсэн тоо 150-аас цөөнгүй, 1-ээс доошгүй докторант эсвэл 3-аас доошгүй магистрант (эсвэл 10-аас доошгүй сайбэр хөтөлбөрийн магистрант) удирдаж хамгаалуулсан бол “дэд профессор” цолны болзлыг биелүүлсэнд тооцож, Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар батламжлан олгоно.
- 3.1.3. Уг журмын 3.1.1, 3.1.2-д зааснаас бусад тохиолдолд “профессор”, “дэд профессор” цолд нэр дэвшигчид ажлын гол үзүүлэлтүүд болох эрдэм шинжилгээ, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаа, нийгэмд үзүүлсэн үйлчилгээний чиглэлээр тавигдах шаардлага, зохих оноог биелүүлсэн байх ёстой. Дараах үе шатаар шалгаруулна. Үүнд:
- 3.1.3.1. АШУУИС-ийн эрдмийн цол олгуулахаар нэр дэвшүүлэх анхны нэгж нь мэргэжлийн тэнхим байна.
- 3.1.3.2. Мэргэжлийн тэнхим нь болзол хангасан эрдэмтэд, багш, эмч нарын материалыг бүрдүүлж хэлэлцээд тухайн цолыг олгуулах саналыг хурлын тэмдэглэл үйлдэн Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлд хүргүүлнэ.
- 3.1.3.3. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөлийн хурлаар нэр дэвшигчийн бүрдүүлсэн материалыг хэлэлцэж, нууц санал хураалтаар дийлэнх олонхын (2/3) саналаар шийдвэрлэнэ.
- 3.1.3.4. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн Зөвлөл нь хурлаар дэмжигдсэн нэр дэвшигчийн Эрдмийн Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарын гарын үсгээр баталгаажуулан бүрдүүлсэн материалыг АШУУИС-ийн Эрдмийн зөвлөлийн Эрдэмтэн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.



- 3.1.3.5. АШУУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн даргын шийдвэрээр томилогдсон Шинжээчдийн комисс нэр дэвшигчдийн бүрдүүлсэн материалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган, Эрдмийн Зөвлөлийн тэргүүлэгчдэд хүргүүлнэ.
- 3.1.3.6. Шинжээчдийн хийсэн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн Эрдмийн Зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн тогтоол, шийдвэр гаргана. Үүнд:
- 3.1.3.6.1 АШУУИС-ийн Эрдмийн цолны шалгуур үзүүлэлтийг биелүүлсэн нэр дэвшигчдийг, шинжээчдийн комиссын дүгнэлтийг үндэслэн хэлэлцэж, Эрдмийн Зөвлөлийн хуралдаанаар шийдүүлэхээр тогтох бөгөөд Эрдмийн зөвлөлийн хуралдаанд оролцсон гишүүдээс тооллогын комисс томилж, нууц санал хураалтаар дийлэнх олонхоор (2/3) санал авснаар шийдвэрлэх
- 3.1.3.6.2 Тогтоолыг үндэслэн АШУУИС-ийн захирлын тушаалаар Эрдмийн цол олгож, Эрдмийн Зөвлөлийн бүх гишүүд оролцсон ёслолын хурал дээр үнэмлэхийг гардуулна.
- 3.2. АШУУИС-ийн "Профессор"-ын ажиллах орон тоон дээр доктор буюу дэд профессор цолтныг (1-2 жилийн хугацаагаар) "Албан тушаалын Профессор" цолтой ажиллуулж болно. "Албан тушаалын Профессор" цолны нэмэгдэл олгохгүй.



АШУУИС-ийн “Профессор”, “Дэд профессор” цолонд нэр дэвшигчдэд тавигдах шалгуур үзүүлэлт


(АШУУИС-ийн Эрдмийн цол олгох журмын 3.1.1.-д заасны дагуу)

д/д	Профессор цолны Шалгуур үзүүлэлт	Дэд профессор цолны Шалгуур үзүүлэлт
1.	АШУУИС-ийн болон АШУУИС-тай гэрээт байгууллагын 2-оос доошгүй докторантын ЭША-ийн удирдагчаар ажилласан байх	АШУУИС-ийн болон АШУУИС-тай гэрээт байгууллагын 1-ээс доошгүй докторантын ЭША-ийн удирдагчаар ажилласан байх
2.	Олон улсын нэр хүндтэй (“Web of Science” мэдээллийн сан) эрдэм шинжилгээний 15-аас дээш импакт фактор бүхий сэтгүүлд нэгдүгээр буюу хариуцлагатай зохиогчоор АШУУИС-ийн нэр дээр 1 өгүүлэл хэвлүүлсэн байх	Олон улсын нэр хүндтэй (“Web of Science” мэдээллийн сан) эрдэм шинжилгээний 10-аас дээш импакт фактор бүхий сэтгүүлд нэгдүгээр буюу хариуцлагатай зохиогчоор АШУУИС-ийн нэр дээр 1 өгүүлэл хэвлүүлсэн байх

АШУУИС-ийн “Профессор”, “Дэд профессор” цолонд нэр дэвшигчдэд тавигдах шалгуур үзүүлэлт

(АШУУИС-ийн Эрдмийн цол олгох журмын 3.1.2 -д заасны дагуу)

д/д	Профессор цолны Шалгуур үзүүлэлт	Дэд профессор цолны Шалгуур үзүүлэлт
1.	АШУУИС-ийн болон АШУУИС-тай гэрээт байгууллагын 2-оос доошгүй докторантын ЭША-ийн удирдагчаар ажилласан байх	АШУУИС-ийн болон АШУУИС-тай гэрээт байгууллагын 1-ээс доошгүй докторант эсвэл 3-аас доошгүй магистрант (эсвэл 10-аас доошгүй сайбэр хөтөлбөрийн магистрант) удирдаж хамгаалуулсан байх
2.	“Scopus” мэдээллийн санд бүртгэгдсэн бүтээлийн Н-индекс 7-аас багагүй, бүтээлийн ишлэгдсэн тоо 300-аас цөөнгүй байх	“Scopus” мэдээллийн санд бүртгэгдсэн бүтээлийн Н-индекс 5-аас багагүй, бүтээлийн ишлэгдсэн тоо 150-аас цөөнгүй байх




АШУУИС-ийн “Профессор”, “Дэд профессор” цолонд нэр дэвшигчдэд тавигдах шалгуур үзүүлэлт

(АШУУИС-ийн Эрдмийн цол олгох журмын 3.1.3 -д заасны дагуу)

д/д	Профессор Үндсэн Шалгуур үзүүлэлт	Оноо	Дэд профессор Үндсэн Шалгуур үзүүлэлт	Оноо
1	АШУУИС-ийн болон АШУУИС-тай гэрээт байгууллагын 2-оос доошгүй докторантын ЭША-ийн удирдагчаар ажилласан байх	20	АШУУИС-ийн болон АШУУИС-тай гэрээт байгууллагын 1-ээс доошгүй докторантын ЭША-ийн удирдагчаар ажилласан байх, эсвэл 3 магистр, эсвэл 10 сайбер хөтөлбөрийн магистр удирдсан байх	20
2	Сурах бичиг, орчуулгын сурах бичиг, Нэг сэдэвт бүтээл /2-оос доошгүй/ туурвисан байх	20	Сурах бичиг, орчуулгын сурах бичиг, Нэг сэдэвт бүтээл /1-ээс доошгүй/ туурвисан байх	20
3	Scopus-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд 3-аас доошгүй өгүүллийг хэвлүүлсэн байх /1-ээс доошгүй нь АШУУИС-ийн нэр дээр хэвлэгдсэн байх/	20	Scopus-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд 1-ээс доошгүй өгүүллийг хэвлүүлсэн байх	20
4	Төслийн удирдагч /PI/ 2-аас доошгүй төсөл, хөтөлбөр удирдах, 1-ээс доошгүй гүйцэтгэх	20	Төслийн удирдагч /PI/1-аас доошгүй төсөл, хөтөлбөр удирдах эсвэл гүйцэтгэх	20
5	Эрдэм шинжилгээний Үндэсний хэмжээний сэтгүүлд өгүүлэл 30-аас доошгүй, үүний 10-аас доошгүй нь дэд профессор цол хүртсэнээс хойш нийтлүүлсэн байх	20	Эрдэм шинжилгээний Үндэсний хэмжээний сэтгүүлд өгүүлэл 20-аас доошгүй, үүний 10-аас доошгүй нь АУ-ны доктор хамгаалснаас хойш нийтлүүлсэн байх	20
д/д	Профессор Туслах Шалгуур үзүүлэлт		Дэд профессор Туслах Шалгуур үзүүлэлт	
1	Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 15 ба түүнээс дээш жил ажилласан байх	10	Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан байх	10
2	Боловсруулж баталгаажуулсан патент, зохиогчийн эрх, ашигтай загвар	10	Боловсруулж баталгаажуулсан патент, зохиогчийн эрх, ашигтай загвар	10
3	Дэд профессор цол хүртээд 5 ба түүнээс дээш жил өнгөрсөн байх	5	АУ-ны докторын зэрэг хамгаалаад 5 ба түүнээс дээш жил өнгөрсөн байх	5
4	Докторын э/ш-ний ажилд шүүмж 2-оос доошгүй хийсэн байх, эсвэл 4-өөс доошгүй магистрын, эсвэл 10-аас доошгүй сайбер хөтөлбөрийн магистрын э/ш-ний ажилд шүүмж хийсэн байх	5	Докторын э/ш-ний ажилд шүүмж 1-ээс доошгүй хийсэн байх, эсвэл 2-оос доошгүй магистрын, эсвэл 6-аас доошгүй сайбер хөтөлбөрийн магистрын э/ш-ний ажилд шүүмж хийсэн байх	5
5	ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд 20-иос доошгүй илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх	5	ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд 10-аас доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх	5
6	Үндэсний эрдэм шинжилгээний хуралд 40-өөс доошгүй илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх	5	Үндэсний эрдэм шинжилгээний хуралд 20-иос доошгүй илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх	5
7	Докторын зөвлөхөөр ажиллах /2-оос доошгүй /	5	Докторын зөвлөхөөр ажиллах /1-ээс доошгүй/	5
8	Магистрын зөвлөхөөр ажиллах /3-аас доошгүй/	2	Магистрын зөвлөхөөр ажиллах /1-ээс доошгүй/	2
9	Гарын авлага, мэргэжлийн ном /3-аас доошгүй/ туурвисан байх	4	Гарын авлага, товхимол /1-аас доошгүй/ туурвисан байх	4

Тайлбар: Үндсэн шалгуур үзүүлэлтийг заавал биелүүлсэн байна. 130-аас дээш босго оноотой үед материалыг хүлээн авна. Илүү биелүүлсэн шалгуур үзүүлэлт тутмыг тухайн үзүүлэлтийн оноонд ноогдох эзлэх хувиар бодож нэмнэ. (Жишээ нь: илүү удирдаж хамгаалуулсан 1 докторант тутамд $(1*20)/2 = 10$ оноо нэмж тооцно)



АШУУИС-ийн “Клиникийн профессор” цолонд нэр дэвшигчдэд тавигдах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Оноо	Нэмэгдэх оноо	Нийт оноо	Тайлбар
1.	Мэргэжлээрээ 15-аас дээш жил ажилласан байх	10	Илүү жил тутамд 0.5		Эмнэлгийн удирдлагын тодорхойлолтоор
2.	Мэргэжлийн тэргүүлэх, зөвлөх зэрэг хамгаалаад 5 ба түүнээс дээш жил ажилласан байх буюу PhD докторын зэрэгтэй байх	10	АУ-ны доктор-5 Зөвлөх- 5 Тэргүүлэх-2 Илүү жил тутамд - 1		Үнэмлэхийн хуулбар
3.	Сүүлийн 3 жил АШУУИС-д гэрээт багшаар ажилласан байх, резидентийн сургалт3-аас доошгүй жил удирдсан байх буюу Орон нутгийн эмч нар 3-аас цөөнгүй удаа оюутны үйлдвэрлэлийн дадлага удирдсан байх	10	Илүү жил тутамд 1		Тэнхимийн хурлын протоколоор баталгаажуулсан байна МДИ-ийн, эсвэл түүнтэй дүйх төгсөлтийн дараах сургалтын байгууллагын тодорхойлолт
4.	Эрдэм шинжилгээний өгүүлэл 15, илтгэл 10- аас доошгүйг нийтлүүлсэн байх	10	Илүү өгүүлэл тутамд -1 Илтгэлд - 0.5		Сэтгүүлийн нүүр, хэвлүүлсэн өгүүлэл, илтгэлийн хураангуйн эхний нүүрний хуулбар
5.	Ном, сурах бичиг 1 -ээс цөөнгүйг туурвисан байх	5	Илүү ажил тутамд 2		Эх бүтээлийн эхний хоёр нүүрний хуулбар, 10-аас доошгүй х.х байна.
6.	5-аас цөөнгүй гарын авлага, удирдамж, стандартын зохиогч байх	5	Илүү ажил тутамд 1		Эх бүтээлийн эхний нүүрний хуулбар
7.	Оношилгоо,эмчилгээний шинэ арга, патент, зохиогчийн эрх, АЗГ, ШБОС нэвтрүүлсэн байх	5	Ажил тутам 2		Албан ёсоор бүртгэгдсэн гэрчилгээний хуулбар
8.	Резидентийн сургалт 3-аас доошгүй жил удирдсан байх	5	Илүү жил тутамд -2		Холбогдох байгууллагын тодорхойлолт

Тайлбар: 1-4 дугаар үзүүлэлтийг заавал биелүүлсэн байна. 50-аас дээш босго оноотой үед материалыг хүлээн авна.

УХД0074 5845459